



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

19 09 19  
сарын 02


Дугаар 4243

Улаанбаатар хот

Комисс шинэчлэн байгуулах  
тухай

1. Бүх төрлийн согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгох, үйлчилгээний зэрэглэл тогтоох нийслэл хотын комиссын бүрэлдэхүүнийг I, нурмийг II, олгох журмыг III, үзүүлэлтийг IV хавсралтаар тус тус баталж, 1993 оны 12 дугаар сарын 25-наас эхлэн мөрдүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1993 оны "Комисс байгуулах тухай" б/21 тоот захирамжийг хүчингүй болгосугай.



Д.БААСАНЖАВ

Нийслэлийн Засаг даргын 1993  
оны 12 сарын 20-ийн зөхирэлжийн I  
хавсралт

БҮХ ТӨРЛИЙН СОЛТУУРУУЛАХ ҮНДАА ХУДАЛ-  
ДАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ~~ХУДАЛДААНЫ~~  
ЗЭРЭГЛЭЛ ТОГТООН ХОТИМКОМИССИИ  
БҮРЭЛДЭХҮН

Комиссийн дарга

-Нийслэлийн Засаг даргын орлогч

Комиссийн орлогч  
дарга

-Нийслэлийн Засаг даргын тамгын газрын  
дарга

Комиссийн нарийн  
бичгийн дарга

-Нийслэлийн Засаг даргын тамгын газрын  
ахуйн үйлчилгээ хариуцсан зохион бай-  
гуулагч

-Нийслэлийн Засаг даргын тамгын газрын  
Нийгэм эдийн засгийн бодлогын хэлтсийн  
үзэ чанар хариуцсан мэргэжилтэн

-Хотын эрүүл ахуй, халцвар судлалын  
хяналтын газрын хүчиний эрүүл ахуйн  
их өмч, улсын байцаагч

-Цагдаагийн ерөнхий газрын хэв журам  
сахиулах хэлтсийн ажилтан

-"Улаанбаатар зочид буудал" компанийн  
ерөнхий захирал

-Хотын татварын албаны хэлтсийн дарга

-Нийслэлийн Засаг даргын тамгын газрын  
худалдааны зохион байгуулалт нийтийн  
хоол хариуцсан зохион байгуулагч

Нийслэлийн Засаг даргын 1993  
оны 4-р тоот захиралжийн  
н хавсралт

БҮХ ТӨРЛИЙН СОГТУУРУУЛАХ УНДАА  
ХУДАЛДАХ ЗӨВШЕӨРӨЛ ОЛГОХ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ КОМИССЫН  
ДҮРЭМ

УХСН

Нэг. Нийтлэг худэслэл

1.1. Бүх төрлийн согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгох, үйлчилгээний зэрэглэл тогтоох нийслэл хотын комисс /цаазид комисс гэна/ нь өөрийн нутаг дэвсгарт ажиллах байгаа зочид буудал, зоогийн газар, баар, хосчин, гоо заслын газруудад үйлчилгээний зөрглэл тогтоож, шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд бүх төрлийн согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгоно.

1.2. Комисс нь нийслэлийн Засаг даргын дэргэд дурмийн дагуу ажиллага.

1.3. Монгол улсын хууль тогтоомж, нийслэлийн Иргэдийн Хурал, Засаг даргын захирамж, бусад эрх зүйн актуудыг комисс улиралдага болгон ажиллана.

Хоёр. Комиссны хураг

2.1. Үйлчилгээтэй холбогдон гарсан Монгол улсын хууль тогтоомж, нийслэлийн иргэдийн хурал, Засаг даргын захирамж, бусад эрх зүйн актуудыг сурталчлах, хэрэгжүүлэх лвшад хяналт тавьж ажиллах.

2.2. Үйлчилгээний зөрглэлийн шаардлага ханган ажиллах буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сурталчлах, удаа дараа зөрчил гомдол гаргасан газарт шалгالت хийж, шаардлагатай арга хэмжээ авах.

2.3. Үйлчилгээний өнөөгийн түвшин, тавигдаж буй шаардлагын талаар комиссны гишүүдэд мэдлэг олгох, тураллага судлуулах аллыг зохион байгуулах.

Гурав. Комиссны эрх

3.1. Комисс нь Монгол улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн актын хурээнд үйл ажиллагаагаа явуулж, нийслэлийн худалдаа, үйлчилгээний газруудын зөрглэл, бүх төрлийн согтууруулах ундаа худалдаалалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь зохицуулж ажиллах.

2.

3.2. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг шалгаж үйлчилгээний зэрэглэл шинээр олгох, еөрчлөх, бүх төрлийн согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгох, шаардлагатай үед үйл ажиллагааг нь зогсоох, зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Засаг даргад тавьж шийдвэрлүүлнэ.

3.3. Комисс тэмдэглэлээр үүрэг даалгавар өгөх, түүний хэрэгжилтийг шалгаж арга хэмжээ авах.

Нийслэлийн Засаг даргын 1993  
оны № 443 тоот захирамжийн  
ш хавсралт

88

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ  
ЖУРАМ

Нэг. Нийтлэг журам

ХУРЫН

1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа өмчийн бүх хэвшлийн зочид буудал, зоогийн газар болон баар, учин, гоо сайхны үйлчилгээний цэг салбарын зэрэглэл тогтоох ажлыг зохион байгуулж мөрдүүлэхэд энэ журмын зорилго оршино.

Хоёр. Үйлчилгээний зэрэглэл тогтоох журам

2.1. Үйлчилгээний зэрэглэл тогтоолгох хүсэлтээ тухайн байгууллага албан тоотоор гаргаж, нийслэл хотын комиссын нарийн бичийн даргад өгнө.

2.2. Комиссын дарга уг хүсэлттэй танилцаад шалгах хэсгийг томилж хүсэлт ирснээс хойш 14 хоногийн дотор шалгуулна.

2.3. Зэрэглэл тогтоох үйлчилгээний байгууллагыг шалгах мөртэжлийн хүмүүсийг оролцуулан нийслэл хотын комиссийн гишүүдийг 3-4 хүнтэй хэсэг болгон хувааж ажиллуулна.

2.4. Хотын комисс үйлчилгээний зэрэглэлийг батлагдсан үзүүлэлтийн цагуу тогтоож 2 хувь тэмдэглэл үйлдэн /тусгай маягттай/ 1 хувийг комиссын нарийн бичийн даргад, нөгөө хувийг тухайн шалгасан цэгт өгнө.

2.5. Зоогийн газар, бааранд зэрэглэл тогтоох комиссын бүрэлдэхүүнд цагдаагийн байгууллагын ажилтныг оролцуулна.

2.6. Тэмдэглэлд үйлчилгээний зэрэглэл тогтоох эсэхийг дүгнэх замж авах арга хэмжээ, үүрэг даалгаврыг ар талд нь тодорхой хугацаа заан бичиж өгөөд гүйцэтгэсэн тухайд нь эргэж шалгана.

2.7. Нийслэл хотын комисс сар бурийн 1,3 дахь 7 хоногийн баасан гаригт хураадаж үйлчилгээний зэрэглэл тогтоохтэй холбогдсон үйлчилгээний зэрэглэл тогтоох, нэмэх, бууруулах, урамшуулах, гэрчилгээг нь хураах, шинэчлэн олгох зэрэг асуудлыг хэлэлцэж сайна.

2.

2.8.Тогтоогдсон үйлчилгээний зэрэглэлийн шаардлага ямар байгааг үе үе шалгах зэрэглэлээ ахиулах бол энэ журмын 2.I-р заалтын дагуу комисст хүснэгтээ гаргана.

2.9.Зэрэглэл олгосон тухай тэмдэглэл, Засаг даргын захирамж гаргаж, 14 хоногийн дотор тухайн цэгийн харьяалах дүүргийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэнэ.

2.10.Зэрэглэлаэр тогтоогдсон түвшинд ажиллах чадахгүй байгаа талаар хөдөлмөрчийн, үйлчилүүлэгчдийн санал, томцол, шалгалтын явцад хяналт тавих эрх бүхий хүмүүс бууутай гаж үзвэл уг цэг салбарын үйл ажиллагааг хаалгах хүртэлх асуудлыг комиссын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

2.11.Гуанзыг дүүргийн хэмжээнд шалгаж, хотын комиссийн гэрчилгээ олгуулах арга хэмжээ авна.

## I. ЗОЧИД БУУДЛЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЗҮҮЛЭЛТ

### I.1. Нийтлэг зүйл

УХЛЭЛИЙН

Зочид түр хугацаагаар байдуулж, тэдэнд зэрэлт хэрэгцээнийх нь дагуу хангамж, үйлчилгээ үзүүлж чадах газрыг зочид буудал гэнэ.

Зочид буудлын өрөөнд зэрэглэлээс хамааруулан дор дурисан зүйлүүп заавал байх ёстой. Үүнд:

-тар ихүрийн, ваннын, хөлний зэрэг алчуурууд;

-нүүр гарын, бие угаадаг саван, оо, сойз, ус, бие угаах шампунь, ус, сахлын ус зэрэг гоо сайхны зүйлүүд;

-сурталчилгааны хантас, захицлын цаас, дүгтүй, ил захидал, телэнс, факс бичих цаас, тэмцэглэлийн /хижиг/ цэвтэр, цаас;

-хувцасны сойз, гутал арчих, тослох зүйлс, улаач, гутал өмсөх халбага, шилний бөглөө онгойлгогч, угаалга, хими цэвэрлэгээ, юм худалдан авахад зориудсан гялгар уут гэх мэт;

-терел бурийн зориулалтын цаасан салфетка, ариун цэврийн зориулалттай уут, бие засах газруудад ариутгал хийсэн тухай зочинд ойлгоц өгөх "ариутгасан" гэсэн цаас байна.

Зочид буудлын гадна тал, хаяг, гэрмэн чимэглэл, орчны тохижилт цэвэрлэгээ, хотын өнгө үзэмжинд сөрөг нелөө үзүүлэхгүй, шаардлагад нийцсэн байна.

### I.2. Люкс зочид буудал

-бүх өрөө нь усанд орох онгоцтой байна.

-нэгээс дээш давхар байшинтай бол тахилгаан шиттэй байх бөгөөд автомобил буюу компьютерийн систем бүхий шат байвал зохино.

-олон зэрэглэлийн өрөөтэй байх ба люкс өрөө нь телевизор, хергүүлтэй байна.

-бүх өрөөнд нь утас /утасын дотоодын буюу шууд станци/ ба радиотой байна. Утасын дотоодын станцтай бол похиоллийн систем байна.

-бүх өрөөнд нь сэргүүлийн төхөөрөмжтэй байна.

-олон талын ажиллагаанд зориулагдсан тусгай танхимуудтай байна.

-зочидын ресторон болон хоёроос доошгүй нийтийн ресторан-

тай байна.

-зочны бүх өрөө, хүйчилгээний танхим /зочид буудлын нийтийн үйлчилгээний байруул, нийтийн хоолны цэг салбарын байруул/ агааржуулах төхөөрөмжтэй байна.

-зочинд зориулсан факс, телекс зэрэг холбооны хэрэглэл байна,

-өрөөнд бичил бартай байна.

-өрөөний иж бүрэн үйлчилгээтэй байна.

-зочин хүлээн авах байранд ээлж тус бурт хоёроос доошгүй гадаад хэлний мэдлэгтэй хүн ажиллавал зохино.

-зочид буудал нь машины грактай байна.

-зочны захиалга авах алба, зочин хүлээн авах алба, тээш хадгалах өрөө, угаалга, индуудлэг, хими цэвэрлэгээ, гутал цэвэрлэх үйлчилгээ /автомат/ ачаа тээш зеөх, мөнгө солих, онгоц, галт тэрэгний болон орон нутгийн тээврийн хэрэгслийн билет олгох, зочин угтах, биөийн таймын танхим, өөрийн автомашины гракж, хөнгөн тэрэгний засварын үйлчилгээ, усчин, гоо сайхан, иллэг, сонин хэвлэл, аллалд зориулсан барааны болон бэлзг дурсгалын барааны дэлгүүр зэрэг үйлчилгээний газруудтай байна.

### I.3. I зэргийн зочид буудал

-бүх өрөө нь шуршүүр буюу онгоцтой байна.

-докс өрөөтэй байна.

-бүх өрөө нь утас /утасны төв/ шууд радиотой байна. Өөрийн утасны төвтэй тохиолдолд дохиоллын системтэй байна.

-нэгзээс дээш давхар зочид буудалд хүн зөөврийн цахилгаан шат байна.

-орчин үеийн болон төвийн халаалттай байна.

-зочдод зориулсан ресторан болон хоёроос доошгүй нийтийн хоолны цэгтэй байна.

-бичил бартай байна.

-өрөөний иж бүрэн үйлчилгээтэй байна.

зочлод зориулсан факс, телекс байна.

-нийтийн хоолны нэгжүүдэд салхивч тавигдсан байна.

-зочид буудал нь өөртөө машины зогсоолтой байна.

-зочин хүлээн авах албаны байранд ээлж тутамд хоёроос доошгүй гадаад хэл мэддэг хүн ажилана.

## 3.

-өдөр шенегүй ажиллах захиалга хүлээн авах алба, зочин хүлээн авах алба болон тээшний өрөө, угаалга индүүдлэг, гутал цэвэрлэх үйлчилгээ, тээш хүргэх, мөнгө солих, онгоц, темер замны билэтийн касс, граждаа хөнгөн төрөг хадгалах, сонин хэвлэл, төрөл бүрийн бараа, бэлэг дурсгалын зүйлийн худалдааны дэлгүүр, мухлаг гэх мэт байвал зохино.

## I.4. II зэргийн зочид буудал:

-зочны бүх өрөөний 75-аас доошгүй хувь нь онгоц, шуршууртэй байна.

-люкс өрөөтэй байна.

-давхар бүрт онгоц, шуршуургүй 20 өрөө тутамд нэг нийтийн усанд орх газар өрөгтэй, эмэгтэй зориулалтаар байна.

-бүх өрөө үтас, радиотой байна.

-утасны төвтэй бол дохиоллын систем байна.

-зочид буудал хоёр давхраас дээш бол цахилгаан шаттай байна.

-нэг реестерэн болон наад зах нь нийтийн хөолны нэг нэгж ажиллах ёстай.

-төвийн халаалттай байна.

-өрөөний их бүрэн үйлчилгээтэй байна.

-зочинд зориулоан факс, төлөөлө байна.

-зочид буудлын дэргэд машинь зогсоол байна.

-зочин хүлээн авах албандаа хоёрсос доошгүй гадаад хэлтэй хүн байна.

-өдөр, шенегүй ажиллах зочны захиалга авах, хүлээн авах алба болон тээшний өрөө, угаалга индүүдлэг, гутал цэвэрлэх, ачаа тээш зөөх, мөнгө солих, ойгоц, галт төрэгний билет, гадаад до тоодын сонин хэвлэл, дэлгүүр, мухлаг зэрэг бусад үйлчилгээний газартай байна.

## I.5. III зэргийн зочид буудал:

-бүх өрөөний гуравны нэг хувь нь онгоц, шуршууртэй байвал зохино.

-халдуун, хүйтэн ус тогтмол байх.

-давхар бүрт 20 усгүй өрөөний дунд өрөгтэй, эмэгтэй нийтийн онгоц, шуршуур, бие засах газар байвал зохино.

-орчин үеийн халаалтын систем байна.

- барилга нь хөёроос дээш давхар бол цахилгаан шаттай байна.
- зочид буудлын мэбель тавилга.
- зочинд зориулсан нийтийн танхим нэгээс дошигүй байна.
- давхар бүрт зочинд зориулсан утастай байна. Буудлын I дүгээр давхрын танхимд утасны кабинтай байна.
- зарим өрөөнд утастай байвал зохино.
- бүх өрөө дохиоллын системтэй байх ба шууд телефон утастай байна.
- зочин буудалдаа өглөөний цай уух боломжоор хангагдсан байхын дээр буудалдаа буюу ойролцоо ресторанд хадуун хөөл идэх боломжоор хангагдсан байна.
- наад зах нь өглөөний хоод өрөөндээ идэх боломж олгож ёстой.
- зочин хүлээн авах албаны нэгээс дошигүй гадаад хөд мэдлэг хүн байна.
- өдөр, шенэгүй захиалга авах, зочин хүлээн авах алба ажиллахын зэрэгцээ тээш хадгалах, угаалга индүүдлэг, рутал цавэрлэх, ачаа тээш зөөх, сонин хэвлэл, жижиг барааны мухлаг, унэт эхий хадгалах сейф зэрэг бусад үйлчилгээтэй байна.

**II.ЗООГИЙН ГАЗАР, БААРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ЗЭРЭГЛЭЛ ТӨГТООХ ҮЗҮҮЛЭЛТ**

**Нийтийн зүйл**

2.1.Хоолны газрын үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, материал техникийн хангалт, орон байрны тохижилт, үйлчилгээний хүрээг харгалзан зоогийн газрыг /ресторан, кафе/, "люкс", "дээд", "нэгдүгээр", "хоёрдугаар", "гурдавугаар", баарыг "люкс", "дээд", "нэгдүгээр"; "хоёрдугаар"; -зушины газрыг "нэгдүгээр", "хоёрдугаар" зэрэглэлд хамруулна. Гуанз зэрэглэлгүй байна.

**2.2.Зоогийн газар**

Зоогийн газар нь зориулалтын орон байранд үндэсний болон одон улсын сонгодог жор, арга ажиллагааны дагуу болон нэрийн хоол, ундаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нарийн дэг журам, өндөр зохион байгуулалттай, сийн чанарын үйлчилгээ, худалдааг явуулдаг хоолны газар юм.

Зоогийн газрын уран барилгын хийц загвар, орон зайн төлөвлөлт, инженерийн байгууламж нь хөолны газрын барилгын норм, дүрэм, технологийн цагуу хийгдсэн, эргул ахуй, ариун цэвэр, гоо зүйн шаардлагад нийцсэн байх бөгөөд хамг, гэрлэн чимэглэл; гадна тохижилт хотоос тавигдах буй шаардлагад нийцнэ.

Зоогийн газар нь захналгат /дайллага, цайллага г.м/ үйлчилгээ зохион байгуулдаг байна. Үйлчилгээний явцад үйлчлүүлэгчдэд тохь тухтай, таатай орчин, нэхцэл бурдүүлэх үүднээс хувцасны өлгүүр, хүлээлгийн танхим, үүпний өрөө, үйлчилгээний танхимыг тухайн газрын үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, нэр хаягтай уялдуулан орчин үеийн болон үндэсний дизайн, гоо зүй, эргул ахуй, ариун цэврийн шаардлагад нийцсэн байдлаар засч тохижуулсан байна.

Зоогийн газрын үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжлийн өндөр ур чадвартай тогооч, үйлчлэгч нар гардан гүйцэтгэнэ. Үйлчилгээний ажилчил /хаалгач, үйлчлэгч/ түгээмэл хэрэглээний 2-оос доошгүй гадаад хэлний мэдэгдэхүүнтэй байх бөгөөд ажлын дүрэмт кувцастай байна.

Зоогийн газар хоолны үйлчилгээ явуулахаас гадна төрөл бүрийн соёл, урлагийн үзүүлбэр зохион байгуулах ба 150-иас дээш суудалтай үйлчилгээний газар, бүжгийн талбай эсвэл тайстай байна. Мөн түүнчлэн өөрийн цуу, хөгжмийн хамтлагтай байх болно.

Үйлдвэрлэл, үйлчилгээний өрөө, тасалгаа, танхим нь зайншигий хэрэгцээт дулааны, механик, нам болон ерлийн хэмийн хөргүүлтэй төхөөрөмж, механик бус тоног төхөөрөмж, хэрэгслээр бүрэн хангагдсан, халаалт, гэрэлтүүлэг, агааршуулалт, цэвэр бокир усны систем нь ариун цэвэр, эргул ахуйн шаардлагад нийцсэн, хэвийн ажиллагаатай байх ёстой.

Тогооч, үйлчлэгч бусад ажиллагчдын багаж хэрэгсэл, ган, шинэн сав суулга, даавуун эдлэл нь ижил загвар хийгдсэн иж сурдэл байханс гадна үйлчилгээний сав, суулга, бусад эдлэл нь түнийн газрын сүлд тэмдэгтэй, үйлдвэрлэл үйлчилгээг тасралтгүй, хэвийн явуулахын тулд хүрэлцэхүйц хамжээтэй байх ёстой.

Зоогийн газар нь үйлчлүүлэгчил, үйлчилгээний ажилчдын агуулгүй байдал, нийгмийн хэв журам сахиулах үүднээс сэргийлэх, хамгаалах алба ажиллуулж болно.

### 2.3. Баар

Баар нь цөөн хүний хүчээр нарийн арга ажиллагаатай холимог болон найруулсан ундаа, хэлбэр хийцийн хөнгөн зууш үйлдвэрлэж, төрөл бүрийн жимс, чихэр, амттан борлуулж үйлчилгээг явуулнааг хоолны газар юм.

Баар нь хоолны газрын барилгын норм, дүрмийн дагуу баригдсан бие даасан байгууламж, эсвэл иж бүрэн барилгын цогцолборт байрлана.

Зоогийн газрын үйлчилгээний танхимд байрласан байвал баарын нэг төрөлд хамрагдана.

Үйлчилгээний танхимын гэл тавилга бол ханын тавиур, үйлчилгээний лангуу, өндөр суудал бөгөөд танхимд цөөн тооны зоогийн ширээ байрлуулж болно.

Баарны гадаад, потоод тохижилт, засал чимэглэл, хаяг, галнах, өнгө үзэмжийг үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогт нийцүүлиж эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу урлаж хийсэн байна. Үйлчилгээний танхимд бужгийн талбай буюу тайз байж болно.

Үйлдвэрлэл үйлчилгээний сав суулга иж бурдэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж нь тухайн газрын онцлогт нийцээн байхаас гадна хүрэлцэхүйц хэмжээтэй байх ёстой.

Баарны худалдагч, үйлчлэгч нэр мэргэжлийн өндөр ур чадвартай, галаад хэлний мэдэгдэхүүнтэй байна. Баарны худалдагч холимог болон бусад ундааны зориулалт, наирлага, бэлтгэх технологи, олгох хэлбэрийг нарийн эзэмшсэн байвал зохино. Мөн түүнчлэн баарны худалдагчийн ажлын байр нь жижиг хөргөгч, мөс балтгэгч, хутгагч, ундаа холигч, угаалгын таннаар тоноглогдсон байх ёстой.

"Люкс", "дээд" зэрэглэлийн бааранд хаалгач ажиллуулна. Үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид ажлын дүрэмт хувцастай байна.

Бааранд төрөл бүрийн урлагийн үзүүлбэр, тоглоом, дурс бичлэг, шуу хөгжмийн үйлчилгээ зохион байгуулж болно.

Зоогийн газрын танхимд баар зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд өндөр суудал нь танхимын нийт суудлын 20-иос

## 7.

хэтрэхгүй хувийг эзэлсан байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний өрөө тасалгаа, агааржуулалтын системд холбогдсон байх шаардлагатай.

#### 2.4. Гуанэ

Гуанэ нь нийтэд болон тодорхой бүлэг хүмүүст зориулж түгээмэл хэрэглээний, цөөн нэр төрлийн хоол ундаа үйлдвэрлэж, үйлчлүүлэгчдийн эрэлтээс хамаарч өглөө, өдөр, орой, эсвэл бүтэн өдрийн турш хоолоор үйлчилдэг газар юм.

Үйлдвэрлэл, үйлчилгээний байр нь хоолны газрын зураг төсөв, технологийн дафуу зохион байгуулагдсан байна. Тэрчлэн зориулалтын бус байрыг өөрчлөн зохион байгуулж гуанз ажиллуулж болно. Энэ нөхцөлд ариун цэврийн байгууллагаас зохих зөвшөөрөл авсан байна.

Үйлчилгээний танхим, үйлдвэрлэлийн болон аж ахуй, агуулжын өрөө тасалгаа, ийжнёрийн хангамж, хоолны газрын барилгын норм дүрэм шаардлагад бүрэн нийцсэн байх ёстой.

Гуанзын гадвах өнгө хээмж, хаяг, гэрлэн чимэглэлийг хотын өнгө үзэмжинд нийцүүлэн хийсэн байна.

Танхимд 2, 6 күний суудалтай гуанзын зориулалттай ширээ байрлуулна. Тогооч нар заавал мэргэжлийн зэрагтэй, зохих дадлага түршлэгатай хүмүүс байна. 50-иас дээш суудалтай гуанзанд үйлчлүүлэгчдэд зориулсан угаалга, ариун цэврийн өрөө байх ёстой.

Үйлдвэрлэл, үйлчилгээний сав суулга, багаж хэрэгсэл /гак хөнгөн цагаан, шаазан/ технологийн тоног төхөөрөмж, лянгуяа нам болон хэвийн хэмтэй хөргөх төхөөрөмжөөр заавал тоноглогдсон байна.

Гуанзын ханы, шал, суудал, ширээ, лянгуу нь цэвэрлэхэд халбар материалыар хийгдсэн байх ёстой.

Хоолны үйлчилгээг бөртөө үйлчлэх хэлбэрээр зохион байгуулина. Харин бөхир таваг, сав суулга, багаж хэрэгслийг хураах тусгай хүн ажиллуулж болно. Хоолны түнийн тооцоог хоолны өмнө ёсвэл эдэст хийнэ. Гуанзыг үйлчилгээний хүрээгээр нь нийтийн /гудамж, талбайн/, дотоодын /үйлдвэр, албан газар, сүргууль, амраалт, сувиллын/, хосолсон үйлчилгээтэй /зочид буудал, үйлдварийн/ гаж ангилана.

## 2.5. Зуушны газар

Зуушны газар нь хязгаарлагдмал нэр төрлийн хөнгөн хоол, зууш, ундаагаар түргэн хугацаанд үйлчилдэг хоолны газар юм.

Зуушны газрын зориулалтын болон зориулалтын бус байранд зохион байгуулах ба өргүл ахуй, ариун цэвэр, үйлдвэрлэл үйлчилгээний технологийн шаардлага хангасан орон байранд үйл ажиллагаа явуулна.

Үйлчилгээний танхимыг босоо ширээгээр тоноглож, үйлчилгээг өөртөө үйлчлэх хэлбэрээр зохион байгуулна. Мөн цөөн тооны 2,4 хүний суудалтай ширээгээр тоноглож болно. Зуушы газар үйлдвэрлэх хоол, ундаар төрөлжсөн байж болно.

Үйлчилгээнд нэг удаагийн эсвэл олон удаагийн хэрэглээний сав суулга, хэрэглэл хэрэглэнэ. Зуушы газрын дотоод засал үйлчилгээ чимэглэлийг юны өмнө ариун цэвэр, өргүл ахуйн шаардлагыг хангахаар хийж урласан байна. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав суулга, хэрэглэл хүрэлцэхүйц хэмжээтэй байна. Тогоочдын-уэ чадвар өндөр байх шаардлагатай.

Зуушы газар нь гудамж талбай, урлаг, соёл, худалдаа үйлчилгээний төв, хүнс, хүнсний биш барааны дэлгүүрт байрлах ба хагас боловсруулсан бүтээгдэхүүний дэлгүүр зуушын газарт хамрагдана.

**Ш.УСЧИН, ГОО ЗАСЛЫН ЦЭГ САЛБАРУУДЫГ  
ЗЭРЭГЛЭЭД ХАМААРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТҮГ**

### Нийтлэг зүйл.

3.1. Үйлчилгээний чанар, соёлжилтийн өндөр шаардлагыг хангасан усчин, гоо заслын цэг салбаруудыг шалгах, үйлчилгээний дээд, I, II зэрэглэл өгнө.

—Усчин гоо заслын цэг салбарууд гаднах тохиижилт, хаяг, гэрлэн чимэглэлийг хотын өнгө үзэмжинд нийцүүлэх бөгөөд цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж байвал зохино.

—Усчин, гоо заслын салбарт гүйцэтгэх байгаа үйлчилгээний зохион байгуулалтыг харгалзан иж бүрэн үйлчилгээтай, төрөлжсөн үйлчилгээтай гэж аngилна.

Иж бүрэн үйлчилгээний цэг салбар нь эрэгтэй, эмэгтэй хүний үс засах, хөл гарын хумс засах, гоо заслын үйлчилгээтэй байна.

Тухайн байгууллага, цэг салбарын нөхцөл шаардлагаас хамаарч үсчний цэг салеарт хөл гарын хумс засах, гоо засал, үсчний үйлчилгээг төрөлжүүлэн хийж болно.

Захиалтыг хүлээн авах, ажил үйлчилгээг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1993 оны 14 тоот тогтоолоор батлагдсан "Ахуйн үйлчилгээний өрөнхий дүрэм"-ийг баримтлана.

Үйлчилгээний үнэ тариф нь гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээнийхээ чанарт тохирсон байх ёстой.

Усчин, гоо заслын цэг салбарууд нь үйлчилгээнийхээ онцлогийг харгалзан хөдөлмөрчдийн тав тухтай үйлчилгүүлэх нөхцлийг хангахуйц зэрэглэлдээ тохирсон хүлээлгийн өрөөтэй байна. Хамгийн бага үсчний газар гэхэд хүлээлгийн сандал нь үсчний ажлын байрны сандлаас 1,5 м-ээс ойргүй байх хэрэгтэй.

-Усчин гоо заслын цэг салбарууд нь гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээнийхээ нэр төрөл, хэлбэр, үйлчлэх цагийн хуваарь, үнэ тарифын жагсаалт болон бусад мэдээллийг агуулсан сурталчилгаатай байна. Сурталчилгаанд гэрлэн чимэрлэл ашиглаж болно.

Усчин, гоо заслын газруудын ажлын байрны талбайн норм хэмжээ, засал болон гэрэл, агаарын тохируулга, тоноглол, үйлчилгээнд хэрэглэгдэх багаж хэрэгсэл, ариун цэврийн материалын хэмжээ нь батлагдсан нормативын шаардлаганд тохирсон байна.

Усчин, гоо заслын газрууд нь хотын захын хороолол, алслагдсан дүүргэг зохих шаардлагыг мөн адил хангасан салбартай байж болно.

### 3.2.Дээд зэрэглэлтэй усчин, гоо заслын цэг салбар:

-Дээд зэрэглэлтэй усчин, гоо заслын цэг салбарт уран сайхны төвийн, чанарын хувьд дээд зэргийн үйлчилгээг орчин үеийн загварын чиглэлийн дагуу үйлчилгүүлэгчдийн саналыг харгалзан хийж гүйцэтгэнэ.

-Уучин, гоо заслын бүх төрлийн үйлчилгээг /тогтоосон төрөлжилтөөр/ явуулна. Янз бурийн тувэгшилтэй гоц чамин болон гоёлын загвараар хөдөлмөрчдийн захиалгын дагуу үйлчилж, сүүлийн чийг дэлгэрч байгаа үс засалт, гоо заслын З-аас доошгүй загварыг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлж хэвцсэн байна.

-Үс тайрч самнах загварын чиглэл, нүүрэнд гоёлын чимэг, будаг тавих бэлдмэлийг шилж сонгож талаар мэргэжлийн зөвлөөг егнэ.

-Үйлчилгээг урьдчилсан захиалга авч гүйцэтгэнэ. Үйлчилүүлэгчийн хүсэлтээр үйлчилгээг гэрт нь очиж хийж болно.

-Дээд зэрэглалтэй уучин, гоо заслын цэг салбарт мастер уучин, гоо засалч буюу мэргэжлийн I зэрэгтэй ажилчид ажилана.

-Батлагдсан нормативын дагуу үйлчилгээний багаж хэрэгсэл, цагаан хэрэглэлийг бүрдүүлж, хангамжийн зохих нөөцтэй байна. Өдөр тутмын үйлчилгээнд шаардлагдах үнэртэн, тос, будгийн хангамж бүх төрлөөр хангалттай байвал зохино.

т-Цэвэр цагаан хэрэглэлийг тусгай саванд хадгалиж нэг удаа хэрэглэхээс гадна үйлчилгээний өмнө багаж хэрэгслийг ариутгаж үйлчилгээ хийдэг журмыг хэвшигүүлсэн байна.

-Үйлчилүүлэгчдээс үйлчилгээний чанарын талаар үнэлэлт авах хайрцагийг үзэгдэхүйц газар байрлуулж үйлчилгээний чанарын үндсэн үзүүлэлтийг /үс, гоо заслын зохимж, чанар, үйлчилгээний соёл, зайн харьцаа, үс засалт, гоо заслын талаар егех зөвлөлгөө г.м бусад үзүүлэлтээр/ тусгасан, энгийн ойлгомжтой хэвлэсэн үнэлэлтийн хуудсыг хүрэлцэхүйц хэмжээгээр хөөцөлсөн байна. Үйлчилгээний чанар үнэлэх хайрцагийг нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохих албан тушаалтан, Монголын хэрэвлэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн ажилтанг байрлуулан улираад З-аас доошгүй удаа нээж, дунг нэгтгэн протокол үйлчилгээний чанарыг үнэлсэн байна.

Нийт саналын 85-аас доошгүй хувь нь үйлчилгээний чанарын талаар хангалттай үнэлэлт авсан байвай зохино. Үлмэх 15 хувийн саналд үндэслэлтэй дутагдал зөрчил байж боложгүй.

## II.

-Ус засах, гоо заслын үйлчилгээний танхимд орчин үеийн хийц-тэй зориулалтын тоног төхөөрөмж, толь, шүүгээ, сандал; тавиур зэргийг гоо зүйн шаардлагын дагуу байрлуулан, өрөө танхимыг уран сайхнаар чимэглэж тохижуулсан байхаас гадна энэ цэг салбарт хэрэглэгдэх химиин бодис, гоо заслын тос болон бусад зүйлийг агуулах, хөргөгч, байгын халуун хүйтэн усны хангамж бүхий толгой угаах зориулалтын тоног төхөөрөмжийг сурилуулж агаар солилцох боломжийг хангасан байна.

- 1. Үйлчилгээний хулээлгийн өрөөнд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Шаардлагатай орчин үеийн хийц бүхий тавилга /үйлчилгээний хулээлгийн сандал, бэлгүүлийн ширээ, хувцасны өлгүүр гэм/ хивсээр тоноглох, цэвэр үзэмжтэй тохилог байлгана.

2. Аятай тухтай үйлчилгээний нөхцлийг бүрдүүлж, хүлээлгийн өрөөг гоо зүйн таашаалд нийцэхийгээр чимэглэн тохижуулж, төлөвизор, хөгжим, харилцах утас зэргийг байрлуулна.

3. Үйлчилгээний лиценз, зэрэглэлийн гэрчилгээ, үйлчилгээний дүрэм, лотоод журам, технологийн гөрим, үнэ тариф, санал сэтгэгдлийн дэвтэр өөрийн салбарыг улсынхан хүмүүсийн нэр хаяг, утасны дугаарыг нийтэд ил харагдахуйц тавьсан байна.

4. Тухайн үйлчилгээний газарт хийгдэж байгаа ажил үйлчилгээ, ус засалт, гоо заслын загваруудыг харуулсан цомог, гэрэл зургууд, сүүлийн үеийн усний хэв маяг, загварын сэтгүүл үйлчилгээнд хэраглэгдэж буй материал хэрэгслийн тухай сурталчилгаа, усээс самнах, арчлах, цууранд чимэг, будаг тавих бэлдмэлийг шилж сонгож талаар зөвлөсөн мэргажийн зөвлөмж зэргийг хүлээлгийн өрөөнд байрлуулна.

Мэдээлэл сурталчилгааны материалыг үе үе шинэчилж байвал зохино.

5. Хүлээлгийн өрөөнд буфет, сокны бар, кафетерийн үйлчилгээг ариун цэврийн зохиц байгууллагаас зөвшөөрөл авсны дагуу гүйцэтгэж, ус, нуур царайгаа арчлахад зориулсан үнэртэн, гоо сайхны бараагаар үйлчилж болно.

-Усчин гоо заслын газар нь байгууллагын нэрээ ил тод, гоо сайхнаар бичиж, гадна талдаа хадсан байхаас гадна байгууллагын

таних тэмдэгтэй, ажилчид нь үйлчилгээний гоо зүйн шаардлагад нийцсэн, бусад газрынхаас ялгараах ажлын хувцастай байна.

3.3. Нэгдүгээр зэрэглэлтэй үсчин, гоо заслын цэг салбар

-Нэгдүгээр зэрэглэлтэй үсчин, гоо заслын цэг салбарт уран сайхны төвшин, чанарын хувьд сайн үйлчилгээг орчин үеийн загварын чиглэлийн дагуу үйлчилгээний саналыг харгалзан хийж гүйцэтгэнэ.

-Үсчин, гоо заслын бүх төрлийн үйлчилгээг /тогтоосен төрөлжилтөөр/ явуулна. Чадин хийцийн болон гоёлын загвараар хөдөлмөрчдийн захиалгын дагуу үйлчилж, сүүлийн үед дэлгэрч байгаа үс засалт, гоо заслын загваруудаас З-аас доошгүйг үйлчилгээнд нэвтрүүлсэн байна.

-Үс тайрч самнах загварын чиглэл, нүүрэнд гоёлын чимэг, будаг тавих бэлдмэлжийг шилж сонгох талаар мэргэжлийн зөвлөгөөг өгнө.

-Үйлчилгээг урьдчилсан захиалга авч гүйцэтгэнэ. Үйлчилгээний хүсэлтээр үйлчилгээг гэрт нь очиж хийж болно.

-Нэгдүгээр зэрэглэлтэй үсчин, гоо заслын газарт мастер үсчин, гоо заалч буюу мэргэжлийн I, II зэрэгтэй ажилчид ажилана. Гэхдээ мастер үсчин, гоо засалч, мэргэжлийн I зэрэгтэй ажилчдын эзлэх хувь 75-аас доош байж болохгүй.

-Батлагдсан нормативын дагуу үйлчилгээний багаж хэрэгсэл, цагаан хэрэглэлийг бурдгуулж, хангамжийн зохиц нөөцтэй байна. Өдөр тутмын үйлчилгээнд хэрэглэгдэх үнэртэн, төс бүдгийн хангамж хэвийн байвал зохино.

-Цэвэр цагаан хэрэглэлийг тусгай саванд халгалж, нэг удаа хэрэглэхээс гадна үйлчилгээний өмнө багаж хэрэгслийг ариутгаж үйлчилгээ хийдэг журмыг хэвшүүлсэн байна.

-Үйлчилгээний чанарын талаар үнэлэлт авах хайрцгийг үзэгдэхүйц газар байрлуулж үйлчилгээний чанарын үндсэн үзүүлэлтийг /үс, гоо заслын зохимж, чанар, үйлчилгээний соёл, зан харьцаа, үс засалт, гоо заслын талаар өгох зөвлөлгөө г.м/ тусгасан, энгийн ойлгомжтой хэвлэсэн үнэлэлтийн хуудсыг

хүрэлцэхийц хэмжаагаэр нөөцөлсөн байна. Үйлчилгээний чанар үнэлэх хайрцгийг нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын зохих албан тушаалтан, Монголын хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийрэмлэгийн ажилтанг байгуулан улиралын З-осс тоошгүй удаа нээж, дунг нэгтгэн протокол үйлцэж Үйлчилгээний чанарыг үнэлнэ.

Нийт саналын 80-аас тоошгүй хувь нь Үйлчилгээний чанарын талаар хангалттай үнэлэлт авсан байвал зохино. Үлдсэн 20 хувийн саналд хийдэслэлтэй дутагдал зөрчил байж болсгүй.

-Ус засах, гоо заслын Үйлчилгээний танхими зориулалтын тоног төхөөрөмж, толь, сандал, тавиур, шүүгээ зэргийг гоо зүйн шаардлагын дагуу байрлуулан, өрөө танхимиг тохижуулсан байхаас гадна химиий бодис, гоо заслын тос болон бусад зүйлийг агуулах хөргөгч, байнгын халуун, хүйтэн усны хангамж бүхий толгой угаах зориулалтын тоног төхөөрөмжийг суурилуулж агаар солилцох боломжийг хангасан байна.

-Үйлчлүүлэгчийн хүлээлгийн өрөө нь гоо зүйн шаардлагын дагуу орчин үеийн тавилгатай, цэвэр үзэмжтэй тохилог байх бөгөөд тэнд Үйлчилгээний лиценз, зэрэглэлийн гэрчилгээ, Үйлчилгээний дүрэм, дотоод журам, технологийн горим, үнэ тариф, санал сэтгэлийн дэвтэр, өөрийн салбарыг удирдах хүмүүсийн нэр, хаяг, утасны дагуурыг нийтэд ил харагдахуйц ил тавьсан байна.

Хүлээлтийн өрөөнд буфет, сокны бар, кафетерийн Үйлчилгээг ариун цэврийн зохих байгууллагаас нэвтрөөрэл авсаны дагуу гүйцэтгэж, үнэртэн, гоо сайхны бараагаар Үйлчилж болно.

-Усчин, гоо заслын газар нь байгууллагын нэрээ ил, тол, гоё сайхнаар бичиж гадна талдаа хадсан байхаас гадна байгууллагын таних тэмдэгтэй, ажилчид нь Үйлчилгээний гоо зүйн шаардлагад нийцсэн ажлын хувцастай байна.

#### 3.4. Хоёрдугаар зэрэглэлтэй усчин, гоо заслын цэг салбар

-Хоёрдугаар зэрэглэлтэй усчин, гоо заслын цэг салбарт уран сайхны төвшийн, чанарыг хангасан Үйлчилгээг орчин үеийн загвар чиглэлийн дагуу Үйлчлүүлэгчийн саналыг харгалзан хийж гүйцэтгэнэ.

-Үйлчилгээг урьдчилсан захиалга авч, эсвэл Үйлчлүүлэгчийн

хүсэлтээр гарт нь очиж гүйцэтгэж болно.

—Хоёрдугаар зэрэглэлтэй уччин, гоо заслын газарт мастер уччин, гоо засалч буюу мэргэжлийн I, II, III зэрэгтэй ажилчид ажилана. Нийт ажиллагчдын дунд мэргэжилтэй ажилчдын эзлэх хувь 90-ээс дооц байж болохгүй.

—Батлагдсан нормативын дагуу үйлчилгээний багаж хэрэгсэл, цагаан хэрэглэлийг бүрдүүлж, едер тутмын үйлчилгээнд хэрэглэгдэх үнэртэн, тос будийн хангамжийг хэвийн байланан.

—Үйлчилгээний омне багаж хэрэгслийг ариутгах үйлчилгээ хийдэг журмыг хэвшигүүлэн, батлагдсан нормативын дагуу нэмрэг, цагаан хэрэгжэлийг З-аас дээш хүнд хэрэглэлгүй угааж ариутгасан байвал зохино.

—Хөдөлмөрчлөөс үйлчилгээний соёл, чанарын талаар үнэлэлт, дүгнэлт байнга авч, түүний мөрөөр тодорхой ажил зохион ажил үйлчилгээний соёл, чанарт ахиц гаргахын төлөө ажилж хэвисэн байна.

—Ус засах, гоо заслын үйлчилгээний танхимд зориулалтын тоног төхөөрөмж, толь, сандал, тавиур, шүүгээ зэргийг гоо зүйн шаардлагын дагуу байрлуулан, өрөө танхимиг тогтмол цэвэр үзэмжтэй байланан.

—Үйлчилгээний хулээлгийн өрөө, хэсэгт үйлчилгээний лиценз, зэрэглэлийн гэрчилгээ, үйлчилгээний дүрэм, журам, технологийн горим, гээ тариф, санал сэтгэгдлийн дэвтэр өөрийн салбарыг удирдах хүмүүсийн нэр, хаяг, утасны нийтэд ил харагдахуйц тавьсан байна.

Хулээлгийн сандал заавал байрлуулна.

Хулээлгийн өрөөнд буфет, кафетериийн үйлчилгээг ариун цэвийн зохих байгууллагаас зөвшөөрэл авсаны дагуу гүйцэтгэж, үнэртэн, гоо сайхны бараагаар үйлчилж болно.

—Уччин, гоо заслын газар нь байгууллагын нэрээ ил тод, гоё сайхнаар бичиж тадна тайдаа хадсан байхаас тадна ажилчид нь үйлчилгээний гоо зүйн шаардлагад нийцсэн ажлын хувцастай байна.